



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/378

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.38 Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII хуралдааны 14, 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөвсгөлд зочлох жил” нэрлэсэн жилийн хүрээнд зохион байгуулагдах Сарлаг наадам-2023 эвент арга хэмжээнд 15.000,000 (арван таван сая) төгрөг, “Тэсийн голын нүүдэлчид өв соёлын наадам” эвент арга хэмжээнд 15.000,000 (арван таван сая) төгрөг, “Алунгоо эхийн сургаалын баяр” эвент арга хэмжээнд 10.000,000 (арван сая) төгрөг, “Монгол бөхийн баяр” эвент арга хэмжээнд 10.000,000 (арван сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Нэрлэсэн жилийн хүрээнд зохион байгуулагдах эвент арга хэмжээний зардал 50.000,000 (Тавин сая) төгрөгийг Засаг дарга дансны “Хөвсгөлд зочлох жил” нэрлэсэн жилийн арга хэмжээний зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Эвент арга хэмжээнүүдийг олон нийтэд сурталчлан, өргөн цар хүрээтэй зохион байгуулж ажиллахыг эвент арга хэмжээг зохион байгуулж байгаа сумдын Засаг дарга нарт, хамтран зохион байгуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Соёл урлагын газар (Л.Батцэцэг)-т тус тус үүрэг болгосугай

4. Хувиарлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулан, тайлагнаж ажиллахыг эвент арга хэмжээ зохион байгуулж байгаа сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6711010031